- 7.5 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргасан тал нь 14 хоногийн өмнө мэдэгдэх ба талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. /Нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ/;
- 7.6 Хэрэглэгч нь цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ 3 удаа биелүүлээгүй тохиолдолд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр гэрээг цуцлах арга хэмжээ авна;
- 7.7 Хангагч, хэрэглэгч нь аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба шийдэлд хүрээгүй тохиолдолд шүүх, хууль хяналтын байгууллагаар маргааныг шийдвэрлүүлнэ;

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Хангагчийн талаас:
ХҮА-ны дарга
Гэрээний инженер



Хэрэглэгчийн талаас:
(гарын үсэг)

(Handwritten signature)

ГЭРЭЭ ХИЙХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Хэрэглэгчийн нэр БАДМААНЯМБУУ.Ц

Факс:

Емэйл:

Албантушаал:

Эзэн

Ц.БАДМААНЯМБУУ

Утас:

99170336,96650337

Нягтлан

Менежер

Инженер

Бусад:

Улсын бүртгэлийн дугаар

Хэрэглэгчийн регистрийн дугаар ЧИ57063001

Хэрэглэгчийн НӨАТ төлөгчийн гэрчилгээний дугаар 0

Шуудангийн хаяг

Хаяг: Улаанбаатар - 06 Хан-Уул - 3 -р хороо Үйлдвэрийн
 гудамж 100-1 тоот

Байршил: Улаанбаатар - 06 Хан-Уул - 3 -р хороо
 Үйлдвэрийн гудамж 100-1 тоот Говь ХК-ийн урд талд

Хэрэглэгчийн харьцдаг банк: Банкгүй

Дансны дугаар: 0

Үйл ажилгааны чиглэл:

Холболт:

Бусад мэдээлэл:

Төсөв:	
Аж ахуй:	
Орон сууц:	
Үйлдвэр:	Мах, махан бүтээгдэхүүн
Бохирдуулагч үйлдвэр:	

Цэвэр ус:	
Төвлөрсөн системээс	X
Гэр хорооллын шугам	
Гүний худагтай	
Зөөвөрөөр	
Бусад	
Бохир ус	
Төвийн коллекторт	X
Цооногтой	
Бохиргүй	
Бусад	

Барилгын талбай м2	0
Давхрын тоо	4
Байрны тоо	1
Ажиллах цаг	0
Ажлын хоног	0
Хүний тоо	0
Тоноглолуудын тоо	
Угаалтуур	4
Суултуур	4
Банн	0
Писсаур	0
Шүршүүр	1

Тоолуурын тухай

Тоолуурын дугаар	Тоолуурын голч /мм/	Тоолуурын оронгийн тоо	Гэрчилгээний дугаар	Тоолуурын төрөл	Марк	Баталгаажсан огноо	Суурилуулсан огноо	Тоолуурын анхны заалт
002127	50	7	00168272	Халуун	WS-25	2020/03/05	2020/03/06	0
009017	32	5	00168260	Хүйтэн	MTL	2020/03/05	2020/03/06	0

Хэрэглэгчийн гэрээний дугаар 26049800

Төлбөрийн дүнг мессежээр хүлээн авах утасны дугаар: 99170336

Хэрэглэсэн усанд төлбөр тавих хугацаа:

Сар

Улирал

Гэрээний төрөл:

Байнгын

Түр

Гэрээ өөрчлөх болсон шалтгаан: Гэрээ шинэчилсэн

Энэхүү хэсгийг УСҮГ-ийн ажилтан бөглөнө.

Техникийн нөхцлийн дугаар: 0

Цэвэр усны цагирагийн дугаар: 79

Худгийн тоо:

Бохир усны коллекторын дугаар: Омнөдийн Ф1400

Худгийн тоо:

Оруулга шугамын голч /мм-ээр/: 106

Ө.Хандийн

Ө.ДАШНЯМ


хангагчийн гарын үсэг

Ц.Бадмаанямбуу

тамга

Ц.БАДМААНЯМБУУ

хэрэглэгчийн гарын үсэг





**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ,
ТЭЭВЭРЛЭХ**

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2025 оны 10 сарын 03 өдөр

№ 25/347

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Нэг талаас Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо, 6278558 тоот регистрийн дугаартай Хан-Уул дүүргийн “ЭКО ХОТЫН ТЭЭВЭР” ААТҮГ /цаашид Гүйцэтгэгч гэх/, нөгөө талаас 5100933 тоот регистрийн дугаартай, Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Захиалагч гэх/ нар доорхи нөхцөлөөр харилан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээ нь 2025 оны 10-р сарын 03-ны өдрөөс 2026 оны 10-р сарын 03-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.3 “Хог хаягдлын тухай” хуулийн хүрээнд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орон сууц, гэр хорооллын айл өрх, ААН байгууллага болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тээвэрлэх, түүнтэй холбогдон гарсан төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.4 Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 09-р сарын 26-ны өдрийн 12/45 дугаар тогтоолоор Хог тээврийн үйлчилгээний хураамжид НӨАТ /нэмэгдсэн өртгийн албан татвар/-ыг тооцоогүй болно.
- 1.5 Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2024 оны 12-р сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоолын дагуу гэрээний үнийн дүнг хоёр тал харилцан тохиролцон тогтоосон болно.
- 1.6 Хороо нь гэрээний дагуу хог хаягдал цуглуулах, тээвэрлэх хуваарийн хэрэгжилтэд хяналт тавьж Захиалагч, Гүйцэтгэгч хороондын уялдааг хангана.

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 2.1 Гүйцэтгэгч нь гэрээнд заасан хуваарийн дагуу ААН байгууллага, орон сууцны бункерийн хог хаягдлыг тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэх, ачилтын мэдээг тухай бүр хороонд мэдээлж ажиллах үүрэгтэй.
- 2.2 Гүйцэтгэгчийн тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол графикт зааснаас бусад цагаар зохион байгуулалт хийн хогийг ачуулах арга хэмжээг авна.

- 2.3 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу ААНБ-аас гарч буй ахуйн хогийг тогтмол цагт цуглуулах, мөн нэмэлтээр барилга барих, буулгах, засварлах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжийн хог хаягдлыг төлбөр төлөгдсөний дараа тээвэрлэнэ.
- 2.4 Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх.
- 2.5 Хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нь зохих сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.
- 2.6 Хорооноос өгсөн чиг үүргийн дагуу Гүйцэтгэгч нь тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулаагүй ААНБ-ын хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.
- 2.7 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

- 3.1 Захиалагч тал “Хог хаягдлын тухай” хуулийг мөрдөж ажиллана.
- 3.2 ААН, байгууллага нь хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хогийн савтай байх.
- 3.3 Тээвэрлүүлэх хог хаягдлыг зөвхөн тогтоосон хог ачилтын цэг буюу бункерт хийх, ачилт хийхэд саадгүй байхаар орц, гарцыг төлөвлөсөн байна.
- 3.4 ААН, байгууллага нь Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4.12, 10 дугаар зүйлийн 2.10 дах заалтуудын дагуу дүүрэг, хорооноос тогтоосон, “**хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар**”-ын хог хаягдал, цас мөсийг цэвэрлэх үүрэгтэй. Цас орж, мөс тогтсон мөн бусад байдлаар бохирдсон тохиолдолд тухайн талбайн цэвэрлэгээг тогтмол хийж, цэвэрлэгээнээс гарах хог хаягдлыг тээвэрлүүлнэ.
- 3.5 Захиалагч тал нь гэрээний 3.2, 3.3-т заагдсан үүргийг биелүүлээгүй улмаас аливаа ААНБ, иргэнд учирсан хохирлыг Захиалагч тал бүрэн хариуцна.
- 3.6 Хог хаягдлын төлбөрийг сар бүрийн 25-нд Хан-Уул дүүргийн **Татварын Хэлтэст** болон **itax.mta.mn** сайтаас төлбөрийн даалгавар үүсгэн төлнө.
- 3.7 Хогийн сав, бункерийн орчимд машин, болон бусад зүйл байрлуулсны улмаас хог ачих боломжгүй болж хог тээвэрлэх автомашин буцах, хугацаа алдсан тохиолдолд холбогдон гарах хариуцлагыг Захиалагч хүлээнэ.
- 3.8 Захиалга буюу хог хаягдал ачих, тээвэрлэх дуудлагыг 2-3 хоногийн өмнө хороо болон гүйцэтгэгчид мэдэгдэнэ.
- 3.9 Хог хаягдал тээвэрлүүлсэний төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэгтэй.
- 3.10 Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх.
- 3.11 Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах.
- 3.12 Гүйцэтгэгчээс ажил үүргээ тогтоосон хугацаанд гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 3.13 Гүйцэтгэгч ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төлбөр төлөхгүй байх эрхтэй.
- 3.14 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүргийг эдэлнэ.
- 3.15

Дөрөв. Төлбөр тооцоо, үнэлгээ

- 4.1 Гэрээт хугацаанд сард 4 удаа иргэн, ААНБ-ийн бункерийн хог, хаягдлыг ачиж тээвэрлэнэ.
- 4.2 Хог тээвэрлэсний төлбөр нь Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон тарифын дагуу харилцан адилгүй байх бөгөөд тухайн байгууллагын хог тээвэрлэлтийн төлбөр дээрх тогтоолд заасны дагуу сард 100,000 төгрөг, улиралд 300,000 төгрөг, жилд 1,200,000 төгрөг байна.
- 4.3 Захиалагч нь E-tax.mta.mn цахим хаягаар орж төлбөрийн даалгавар үүсгэн нэхэмжлэхийн дугаараар хог хаягдлын хураамжаа хугацаанд нь бүрэн төлнө.

- 4.4 “Хог хаягдлын тухай” хууль, бусад эрх зүйн актыг үндэслэн зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хамаарч үйлчилгээний үнийн тарифт өөрчлөлт оруулж болно.
- 4.5 Хог тээвэрлэлтийн тарифт өөрчлөлт орсон тохиолдолд талуудын төлөөлөл тохиролцон гэрээнд нэмэлт оруулж мөрдөнө. Хэрэв хатуу хог хаягдал болон барилгын засвараас гарсан чулуу, мод, шорооны хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд нэмэлт тарифыг мөрдөх бөгөөд төлбөрийг төлсний дараа гүйцэтгэгч тээвэрлэнэ.
- 4.6 Үйл ажиллагааны онцлогоос хамаарсан хог хаягдлын тээвэрлэлтийг өвөл, зуны батлагдсан графикийн дагуу төлбөр төлөгдсөний дараа тээвэрлэнэ.
- 4.7 Хог тээвэрлэлтийн төлбөрийг ААН, албан байгууллага, үйлчилгээний газрууд нь гэрээний 3.6-д заасан хугацаанд бүрэн төлж барагдуулна. Төлбөрийг хожимдуулсан тохиолдолд хоног тутам 0,5%-ийн алданги төлнө.

Тав. Хамтран хүлээх хариуцлага

- 5.1 Талууд энэхүү гэрээ зөрчигдөөгүй тохиолдолд дангаараа гэрээг цуцлах эрхгүй.
- 5.2 Талууд аливаа маргаан, үл ойлголцлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол холбогдох хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
- 5.3 Нийслэл, дүүргээс зохион байгуулах их цэвэрлэгээний ажилд дайчлагдан ажиллах үед хог ачилтын хуваарь 1 өдрөөр хойш шилжих асуудал гарч болно. Үүнийг тухайн ААН, байгууллагад урьдчилан мэдэгдэх бөгөөд төлбөр төлөлтөнд ямар нэгэн өөрчлөлт орохгүй.

Зургаа. Торгуулиас чөлөөлөгдөх нөхцөл

- 6.1 Байгаль, цаг уурын онц ноцтой үзэгдэл тохиолдох, хүндэтгэх шалтгаанаар авто зам хаагдсаны улмаас хог ачих боломжгүй болсон.
- 6.2 Удирдах, дээд байгууллагын шийдвэрээр автомашиныг өөр ажилд дайчилсан тохиолдолд энэхүү гэрээний 5.2 дахь заалт хамаарахгүй.

Долоо. Бусад

- 7.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 7.3 Тус гэрээнд дүүрэг, хорооноос тогтоосон **“хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар”**-ын зураглалыг хавсаргасан тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзнэ.

Найм. Нэмэлт өөрчлөлт

20... оны сарын –ний өдөр талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулав.

Ажлын ТӨВЛӨРСӨН ЦЭГ ачилт хийх.

Ес. Гэрээний сунгалт

- 9.1 Гэрээний хугацаа дуусаж, талууд гэрээг цуцлах талаар албан бичгээр санал гаргаагүй бол гэрээг анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 9.1.1 Энэхүү гэрээг 20 оны сарын өдрөөс 20 оны сарын өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ _____ сунгасан:

Гэрээ _____ сунгасан:

Тайлбар: _____

9.1.2 Энэхүү гэрээг 20... оны ... сарын ... өдрөөс 20.. оны ... сарын ... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.


Гэрээ _____ сунгасан:

Гэрээ _____ сунгасан:

Тайлбар: _____

Гүйцэтгэгч тал:
Эко хотын тээвэр ААТҮГ-ын
Гэрээ, гүйцэтгэлийн Ахлах
мэргэжилтэн албан тушаалтай
.....
/ С.Одгэрэл /
Утас: 9009-1401
Хаяг: Хан-Уул дүүрэг 20-р хороо
Хан -Уул таур 6 давхар 607 тоот
Хог тээвэр захиалга: 77118750
89080307
91544747

Захиалагч тал:
Захирал
.....
/ Ц.Бадмаанямбуу /
Утас:99170336, 80435555
Хаяг: Хан-Уул дүүргийн 3-р хороо,
Үйлдвэрийн гудамж 100-1 тоот.



2024 оны 10 сарын 21-ны өдөр

№ 8024-21/ГХХ

Улаанбаатар хот

Энэхүү аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол улсын Иргэний хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг тус тус үндэслэн болгон:

(ҮҮСГЭГЧ) “АР СИ ИНСПЕКШН АЗИА АССАЙРС” ХХК	(ХҮЛЭЭН АВАГЧ) “ТҮМЭН ЭГШИГ” ХХК
Монгол Улс, Улаанбаатар 15141, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж 24, М Плаза, 17-р давхар, 1701 тоот	Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14 хороо, Намьянжугийн гудамж 44-өөрийн байр
Регистрийн дугаар: 5723612 Утас: 976-99110734	Регистрийн дугаар: 5031923 Утас: 88990428, 91918828
Үүсгэгчийн эрх бүхий төлөөлөгч: Лабораторийн менежер Ц.Гүндэгмаа lab@rcinspection.mn	Хүлээн авагчийн эрх бүхий төлөөлөгч: Ерөнхий менежер Б.Одбаяр chemicalwasterisk@gmail.com
Үүсгэгч болон Хүлээн авагч нь (тус тусад нь “Гал, хамтад нь “Галуул” гэх) энэхүү гэрээг байгуулж, доорх нөхцөлөөр харилцан тохиролцов.	

НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

- 1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичигт заасан олон төрлийн хаягдал /цаашид “аюултай хаягдал” гэх/-ыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
- 1.2. Аюултай хаягдал хүлээн авагч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байна.
- 1.3. Аюултай хог хаягдлын төрөл түүнийг устгах нэгж үнийг гэрээний Хавсралт №1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртгээ дагалдах бичгийг баталгаажуулан энэ гэрээнд хавсаргана.
- 1.4. Энэ гэрээ нь 2024 оны 10 сарын 21-ны өдрөөс 2027 оны 10 сарын 21-ны өдрийг хүртэл 3 жилийн хугацаатай байна.

ХОЁР. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дараах зүйлийг тэмдэглэсэн байна. Үүнд:
 - 2.1.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээг тавьсан байх;
 - 2.1.2. Аюултай хог хаягдлыг савласан сав бүрт ямар хаягдал байгаа талаарх нэр шошготой байх;

Үүсгэгч тал: 

1

Хүлээн авагч тал: 

- 2.1.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртгээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хөтлөн хүлээн авагчид шилжүүлэн өгөх;
- 2.1.4. Хүлээн авагч нь аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлэж хүлээн авах ба тээвэрлэлтийн гэрээг талууд тусад байгуулна.
- 2.1.5. Хүлээн авагч нь аюултай шилжүүлэн өгөх үед тавигдах шаардлага, хог хаягдлыг хэрхэн хуримтлуулах талаар үүсгэгчид шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг тухай бүр өгнө.

ГУРАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР

- 3.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлын үүссэн хуримтлал, цаашид хуримтлал үүсгэхэд сав баглаа боодлын хүрэлцээгүй тохиолдолд Хүлээн авагчид шилжүүлнэ.
- 3.2. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ Хүлээн авагчид албан бичиг эсвэл и-мэйлээр 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 3.3. Хүлээн авагч нь Үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товчлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
- 3.4. Үүсгэгчийн шилжүүлэх аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах бүх зардлыг Хүлээн авагч тал хариуцна.
- 3.5. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлэх, хүргэлтийн цэгт хүргэх тохиолдолд тээврийн үнийн саналыг Хүлээн авагчаас урьдчилан авч энэ гэрээний Хавсралт №2 баталгаажуулсан байна.
- 3.6. Талууд устгуулахаар шилжүүлсэн аюултай хаягдлын тоо хэмжээ, нэр төрлийг Хавсралт №3-аар баталгаажуулах бөгөөд тус баталгаажуулсан баримт, Хүлээн авагч талын нэхэмжлэхийг үндэслэн гэрээний төлбөрийг ажлын 10 хоногийн дотор Хүлээн авагчид шилжүүлнэ.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:

- 4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг Хүлээн авагчаас шаардах эрхтэй.
- 4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.4-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүлээлгэн өгнө.
- 4.1.3 Үүсгэгч нь аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, Тээвэрлэгчид 1 хувь, Хүлээн авагчид 2 хувийг илгээж, Хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.
- 4.1.4 Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.
- 4.1.5 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг Хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ.

4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг

- 4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.4-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах эрхтэй.
- 4.2.2 Хүлээн авагч нь худалдан борлуулсан химийн хорт болон аюултай бодисоос үүдэлтэй хог хаягдлыг өөртөө шилжүүлэн авч, устгах, хадгалах, дахин боловсруулах ажлыг гүйцэтгэх, химийн бодисын хог хаягдалтай холбоотой аливаа асуудлаас үүсгэгчийг ангид байлгах үүрэгтэй.
- 4.2.3 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг Үүсгэгчид гаргаж өгнө.
- 4.2.4 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг шилжүүлэн авсанаас хойш түүний хадгалалт, дахин боловсруулалт, устгал зэргийг бүрэн хариуцна.
- 4.2.5 Үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

ТАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ, ШИЛЖҮҮЛЭН АВАХ

- 5.1. Үүсгэгч аюултай хог хаягдлын мэдээллийг 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэн аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй.

Үүсгэгч тал: 

2

Хүлээн авагч тал: 

- 5.2. Хүлээн авагч нь аюултай хог хаягдлаа “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлэн хүлээн авна.
- 5.3. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж Хүлээн авагч тал хүлээн авна.
- 5.4. Аюултай хог хаягдлыг ачиж, буулгах хүн хүч болон гарах зардлыг Хүлээн авагч тал хариуцна.

ЗУРГАА. ӨМЧЛӨХ ЭРХ ШИЛЖИХ

- 6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.
- 6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг Хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх Хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.
- 6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр Хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний эрсдэл Үүсгэгчид байх ба Хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр эрсдэл Хүлээн авагчид шилжинэ.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

- 7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.
- 7.2. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.4-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд хог хаягдлыг тээвэрлэлт болон хадгалалтын зардлыг Үүсгэгчид төлнө.
- 7.3. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг Иргэний хууль болон энэ гэрээнд заасан журмын дагуу зохицуулна.
- 7.4. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт №1-д заасан тоо хэмжээ, аюултай хаягдлын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.
- 7.5. Энэхүү гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 8.1. Талуудын аль нэг нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Дээрх нөхцөл байдал болон түүний үр дагавар арилмагц үүргээ нэн даруй гүйцэтгэнэ. Тус нөхцөл байдалтай холбоотойгоор гэрээний хугацаанд өөрчлөлт орохоор бол хоёр тал харилцан тохиролцоно.
- 8.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас энэхүү гэрээ саатсан буюу хэрэгжих боломжгүй талаар хүсэлт гаргасан тал нь нотолсон тохиолдолд гэрээний нөгөө тал тус хугацааны алданги, торгууль нэмэлт үүргээс чөлөөлөгднө.
- 8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал утсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг Үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойших эрсдэлийг Хүлээн авагч хариуцна.

ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, талууд тус бүр 1 хувийг хадгална. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд зөвхөн бичгээр оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

Үүсгэгч тал:

3

Хүлээн авагч тал:

- 9.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, гэрээг дуусгавар болгох, хугацаанаас нь өмнө цуцлах тухай мэдэгдэл гэх зэргээр гэрээтэй холбоотой гаргаж буй аливаа мэдэгдэл, албан бичиг, санал, хүсэлтийг зөвхөн бичгээр баталгаажуулах ба талуудын албан ёсны хаягаар бичлэн, шуудангаар эсвэл албан ёсны электрон хаягаар хүргүүлнэ.
- 9.4. Талууд гэрээтэй холбогдон гарсан аливаа асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



Үүсгэгч тал:

4

Хүлээн авагч тал:

“.....” ХХК, болон “Түмэн эгшиг” ХХК-ийн
 хооронд байгуулсан 2022 оны 10 дугаар сарын 10 -ны өдрийн
 тоот Аюултай хог хаягдал шилжүүлэх
 гэрээний Хавсралт №1

Аюултай хог хаягдлын нэгж үнэ

№	Аюултай хаягдлын төрөл	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгж үнэ /төг/	Нэгж үнэ /НӨАТ/
1	Химийн бодисын хаягдал хуванцар, сав, канистр /0,5л, 1л, 2,5л, 5л, 10л, 25л/	тн	1	1,150,000	1,265,000
2	Химийн хуванцар торх / 100л/	ш	1	4,800	5,280
3	Химийн хуванцар торх /200л/	ш	1	7,900	8,690
4	Химийн хуванцар ИВС танк /1000л/	ш	1	28,000	30,800
5	Гялгар уут, шуудай, /25кг, 50кг, 1тн big bag шуудай/	тн	1	1,250,000	1,375,000
6	Төмөр торх боошиг	ш	1	8,200	9,020
7	Химийн бодисийн шил,сав	ш	1	2,000	2,200
8	Химийн хатуу хуурай хаягдал	кг	1	5,600	6,160
9	Химийн хаягдал шингэн уусмал 1литр	л	1	6,000	6,600
10	Хаягдал аккумулятор	ш	1	4,000	4,400
11	Масло шүүр том оврийн	ш	1	2,800	3,080
12	Принтерийн хор	ш	1	2,500	2,750
13	Тосны шүүр	кг	1	1800	1980
14	Агаар шүүгч	кг	1	2100	2310
15	Хаягдал лаг	кг	1	3,800	4,180
16	Хаягдал цаас бохирдсон	кг	1	600	660
17	Хаягдал маск болон бээлий нийлэг материал	кг	1	3000	3,300
18	Хаягдал шингээгч даавуу химийн бодистой тостой	кг	1	3,500	3,850
19	Хаягдал төмөр материал болон бусад	кг	1	2,500	2,750
20	Хаягдал лааз сав	ш	1	1100	1,210
21	Хаягдал батгарей	кг	1	3500	3,850
22	Ашигласан масло, тос	л	1	600	660
23	Хөргөлтийн шингэн тосол	л	1	1000	1,100
24	Галын хорны баллон жижиг/ дунд	ш	1	3500	3,850
25	Галын хорны баллон том	ш	1	4000	4,400
26	Бохирдсон хөрс тостой	тн	1	1,600,000	1,760,000
27	Эмнэлгийн хаягдал	кг	1	5500	6,050
28	Хаягдал дугуй	том	1кг	400	440
29	Хаягдал дугуй	жижиг	1кг	600	660
30	Хар тугалганы хаягдал	кг	1	1200	1320
31	Нонель гуурс	кг	1	950	1045

Үүсгэгч талыг төлөөлж:



Хүлээн авагч талыг төлөөлж:



“.....” ХХК, болон “Түмэн эгшиг” ХХК-ийн
 хооронд байгуулсан 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
 тоот Аюултай хог хаягдал шилжүүлэх
 гэрээний Хавсралт №3

Аюултай хаягдлыг хүлээлцэх баримт

№	Аюултай хог хаягдал нэр	Аюултай хог хаягдлын төрөл	Аюултай хог хаягдал хуримтлуулсан сав баглаа боодлын мэдээлэл	Үүссэн тоо хэмжээ /ш, кг, тонн/	Аюултай хог хаягдлыг устгах нэгж үнэ	Аюултай хог хаягдлыг устгах нийт үнэ
1						
2						
3						
4						
5						
6						
Нийт						

Нийт тээврийн зай км байна.

Аюултай хог хаягдлыг шилжүүлэн өгсөн:

Аюултай хог хаягдлын хүлээн авсан:

.....

.....

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
 2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
 тушаалын 1 дүгээр хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

№
 Дагалдах бичгийн дугаар:

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл: Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: У- 001668 Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: “.....” ХХК								
2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:								
Овог нэр	Албан тушаалтан	Гарын үсэг:	Огноо:					
.....	2024 он сар..... өдөр					
3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл: 1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:.....								
4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:								
	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилалын зэрэглэл	Савлаганы бүлэг	Савны		Хэмжээ	Нэгж /кг Эсвэл/ ш	Аюултай хог хаягдлын код
				дугаар	Төрөл			
1								
2								
3								
4								
4. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:								
6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч :								
1. Овог нэр:.....		Гарын үсэг:.....		2022 он сар..... өдөр				
7. Үл зохицол:								
8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл: Аж ахуйн нэгжийн нэр: ТҮМЭН ЭГШИГ ХХК “Түмэн эгшиг” ХХК бүртгэлийн дугаар: Аюултай хог хаягдлыг хүлээн авсан: Овог нэр : “Түмэн эгшиг” ХХК Албан тушаал Гарын үсэг/ тамга / Огноо 2022 он сар ... өдөр								

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ,
ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 0300034

Огноо: 2024.08.07

Хавсралт 1 -д заасан нөхцлийн дагуу аюултай хог хаягдал
Химийн бодисын сав, баглаа боодол дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг
(зөвшөөрлийн төрөл)
9011053065 улсын бүртгэлийн дугаартай 5031923
регистрийн дугаартай Түмэн эгшиг ХХК -д 2024 оны 08 дугаар сарын 07 -ны
өдрөөс 2029 оны 08 дугаар сарын 07 -ны өдөр 5 жилийн хугацаагаар олгов.

Үйл ажиллагаа эрхлэх талаарх мэдээлэл:

Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа
эрхлэгчийн бүртгэлийн дугаар 0000022
Аж ахуйн нэгж/иргэний хаяг: Улаанбаатар хот аймаг, хот Сүхбаатар
сум, дүүргийн 16-р хороо баг, хорооны Ойчдын 1, 128
(гудамж, байшин/хөөлөгний дугаар)
Зөвшөөрөл олгосон үйл ажиллагаа явуулах газрын байршил: Төв
аймаг, хот Сэргэлэн сум, дүүргийн 1 дүгээр
баг, хорооны (газрын нэр/гудамжны нэр, дугаар)

Хавсралт нь энэхүү зөвшөөрлийн салшгүй нэг хэсэг болно.

Зөвшөөрөл олгосон:

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
САЙД

(байгууллагын нэр, албан тушаал)



С.ОДОНТУЯА

(олог нэр)

2024 оны 08 сарын 07 өдрийн
0000034 зөвшөөрлийн
1 хавсралт

№	Тушаалын дугаар	Хугацаа	Өлгөсөн өдөр
1	A/660	2024.08.07-2029.08.07	2024.08.07
2			
3			
4			
5			

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД
(байгууллагын нэр, албан тушаал)



С.ОДОНТУЯА
(олог нэр)

САНАМЖ:

Тус яамнаас өлгөсөн энэхүү гэрчилгээг зориулалтын бусаар ашигласан, үйл ажиллагаандаа ноцтой алдаа дутагдал гаргасан, худалдан борлуулсан, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн бол хүчингүй болгох үндэслэл болно.



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2023 оны 09 сарын 22

№29/23
30/23

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын Хуулийн этгээд, Улсын бүртгэлийн 9011420015 тоот гэрчилгээтэй, Регистрийн 5723612 дугаартай “АР СИ ИНСПЕКШН АЗИА АССАЙРС” ХХК / цаашид Захиалагч тал гэх / түүнийг төлөөлөн Хүний нөөцийн менежер ажилтай Ц.Дулмаа, нөгөө талаас 2672049 регистрийн дугаартай “Буянт-Оношлогоо” ХХК, түүнийг төлөөлөн нягтлан бодогч ажилтай Д.Баянзул /цаашид Гүйцэтгэгч тал гэх / хамтад нь талууд гэх / нар нь тэгш эрх, сайн дурын үндсэн дээр Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээгээр нэг талаас Гүйцэтгэгч нь Захиалагчийн захиалгын дагуу тус байгууллагын ажилтнуудад Эрүүл мэндийн тандалт, хөтөлбөрийн дагуу ажил мэргэжлийн тохироог үзэх үзлэг, шинжилгээг орчин үеийн дэвшилтэт техник технологийг ашиглан гүйцэтгэж, шинжлэх ухааны нотолгоонд суурилсан үндэслэлтэй хариуг Захиалагчид илгээх, нөгөө талаас Захиалагч нь эрүүл мэндийн үзлэгийн хариуг хүлээн авч гэрээгээр тохиролцсон хөлсийг хугацаанд нь төлөх үүргийг тус тус хүлээнэ.
- 1.2 Гүйцэтгэгч нь эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийг үндэслэн гэрээнд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 1.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гүйцэтгэх газар нь Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, UBH center 5 давхарт байрлах “Буянт-Оношлогоо” Эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байр байна.
- 1.4 Гүйцэтгэгч нь Эрүүл мэндийн тандалт, хөтөлбөрийн дагуу ажил мэргэжлийн тохироог үзэх үзлэг, шинжилгээний хариуг захиалагч байгууллагын хариуцсан захиргааны ажилтан эсхүл хүний нөөцийн менежер лүү битүүмжлэн нэгдсэн байдлаар илгээнэ. Мөн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан захиалагч байгууллагын ажилтанд үзлэгийн хариуны холбогдох хэсгийг илгээж болно.
- 1.5 Гүйцэтгэгч нь Захиалагчид гэрээний Хавсралт №1-д заасан нэр төрөл, үзүүлэлт бүхий эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Энэхүү гэрээний үйлчлэх хугацаа нь 2023 оны 09 сарын 25-ны өдрөөс 2026 оны 09 сарын 25-ны өдрийг дуустал 3 жилийн хугацаатай байна.
- 2.2 Гэрээгээр тусгайлан заагаагүй хугацааны хувьд /ажлын хоног гэж заагаагүй тохиолдолд/ календарийн тооллыг удирдлага болгоно.
- 2.3 Гэрээг сунгах тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас өмнө ажлын 10 хоногийн өмнө талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 2.4 Гэрээний аль нэг тал цуцлах санал гаргаагүй бол гэрээ нь анх байгуулагдсан хугацаагаар дахин сунгагдсанд тооцно.

Гурав. Талуудын эрх, үүрэг

- 3.1 Захиалагч нь дараах эрх, үүрэгтэй:

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас: 1/8

- 3.1.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.
- 3.1.2 Гүйцэтгэж буй ажилтай холбоотойгоор санал, хүсэлтээ гүйцэтгэгч талд өгөх эрхтэй.
- 3.1.3 Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирол болон зардлаа гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.
- 3.1.4 Гэрээнд заасан хугацаанд төлбөрийг бүрэн төлөх үүрэгтэй.
- 3.1.5 Гэрээний биелэлтийг хангах зорилгоор өөрийн ажилтнуудаас гүйцэтгэгчтэй харьцах ажилтныг томилох үүрэгтэй.
- 3.1.6 Захиалагч нь гэрээгээр гүйцэтгэх ажилтай холбоотой мэдээллээр хангах үүрэгтэй.
- 3.1.7 Гүйцэтгэгч нь захиалагчийн зүгээс үзүүлж буй үзлэг, шинжилгээтэй холбоотой хувийн бэлтгэлийг хангах зааварчилгааг өөрийн байгууллагын ажилтнуудад мэдээллэх үүргийг хүлээнэ.
- 3.1.8 Эрүүл мэндийн үзлэгийг тухай бүр хүлээн авч, гэрээнд заасан төлбөрийг төлөх үүрэг хүлээнэ.

3.2 Гүйцэтгэгч нь дараах эрх, үүрэгтэй:

- 3.2.1 Захиалагчийг энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 3.2.2 Үйлчлүүлэгчийг үзлэг хийлгэхэд шаардагдах зохих бэлтгэлийг ханган ирсэн байхыг шаардах эрхтэй. Хэрэв үйлчлүүлэгч нь үзлэгийн зохих бэлтгэлийг ханган ирээгүй ба энэ нь үзлэгийн хариу үнэн зөв гарахад нөлөөлөхөөр бол захиалагч компанид энэ талаар мэдэгдэн дараагийн үзлэгт цаг олгох үйл ажиллагааг зохион байгуулна.
- 3.2.3 Гүйцэтгэгч нь Захиалагчийн захиалгын дагуу тус байгууллагын ажилтнуудын үзлэг, шинжилгээг орчин үеийн дэвшилтэт техник технологийг ашиглан үр дүнтэй хийж, шинжлэх ухааны нотолгоонд суурилсан үндэслэлтэй хариу гаргаж өгөх үүрэгтэй.
- 3.2.4 Үйлчлүүлэгчийн хувийн мэдээлэл болон авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариутай холбоотой мэдээллийг эмнэлгийн ERP системд хугацаагүйгээр хадгалах үүрэг хүлээнэ.
- 3.2.5 Гүйцэтгэгч нь захиалагчийн захиалсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтнуудаар гүйцэтгүүлэх ба тухайн байгууллагын эмч, ажилтнууд нь үзлэг хийж, дүгнэлт хариу гаргахдаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллаж, өөрийн байгууллагын үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үнэн зөв, бодит, баталгаатай байдлыг хариуцна.
- 3.2.6 Гүйцэтгэгч нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх стандартын шаардлага хангасан гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай, зориулалтын байранд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх үүргийг хүлээнэ.
- 3.2.7 Гүйцэтгэгч нь үзлэг, шинжилгээний хариуг цаасан хэлбэрээр захиалагчийн эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгч, хүлээлгэн өгсөн он, сар, өдрийг тэмдэглэн, хүлээн авсан эрх бүхий албан тушаалтны гарын үсгийг зуруулан авна.

Дөрөв. Төлбөрийн нөхцөл

- 4.1 Гүйцэтгэгчийн үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үнэ нь гэрээний хавсралт №1-т заасан тарифт үнэ байна.
- 4.2 Гүйцэтгэгчийн зүгээс ажил мэргэжлийн тохироог үнэлж, дүгнэлт гаргахтай холбоотойгоор Хавсралт №1-т дурдаагүй нэмэлт үзлэг, шинжилгээг хийх шаардлагатай болсон тохиолдолд үйлчлүүлэгчид энэ талаар танилцуулан нэмэлт үзлэг, шинжилгээ хийгдсэний дараагаар Хавсралт №1-т заасан үзлэг, шинжилгээг хийнэ. Үйлчлүүлэгчийн зүгээс гүйцэтгэгчээр тус үзлэг, шинжилгээг хийлгүүлэхээр болвол үнийн талаарх мэдээллийг танилцуулан нэмэлт үнийг захиалагчийн ажилтан буюу үйлчлүүлэгч өөрөө хариуцна.



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас: 2/8

4.3 Гүйцэтгэгч нь захиалагчаас захиалсан үзлэг, шинжилгээний тоог үндэслэн энэ гэрээний 4.1-д заасан төлбөрийг сар бүрийн 30-ны өдөр нэхэмжлэх ба захиалагч нь төлбөрийн нэхэмжлэхийг үндэслэн дараа сарын 5-ны өдрийн дотор төлбөрийг шилжүүлнэ. Төлбөрийг гүйцэтгэгчийн доорх дансанд шилжүүлнэ.

Данс эзэмшигчийн нэр: Буянт-Оношлогоо ХХК

Дансны дугаар: 1705114007

Банкны нэр: Голомт банк

4.4 Захиалагч нь энэ гэрээний 4.3-т заасан үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй нь гүйцэтгэгч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гүйцэтгэхээс татгалзах үндэслэл болно.

Тав. Давагдашгүй хүчин зүйл

5.1 Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйл /ган гачиг, үер, газар хөдлөлт, гал түймэр, хорио цээр, дайн самуун, эрх бүхий байгууллагын шийдвэр, үйлдвэрлэгчийн үйл ажиллагааны доголдол, бүх нийтийн ус цахилгааны хязгаарлалт зэрэг талуудын хүсэл зоригоос ангид аливаа үйл ажиллагаа/-ийн улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх бөгөөд гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдана.

Зургаа. Талуудын хүлээх хариуцлага

6.1 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа хохирол учруулсан бол учруулсан хохирлоо буруутай тал нь төлөх үүрэгтэй.

6.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас торгууль, алданги төлсөн явдал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

6.3 Захиалагч нь гэрээгээр тохирсон хөлс төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг ажил гүйцэтгэгчид төлнө.

Долоо. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах

7.1 Гэрээнд дор дурдсан журмаар нэмэлт өөрчлөлт оруулна.

7.1.1 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэ гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах ба уг нэмэлт өөрчлөлт нь гагцхүү бичгээр үйлдэгдэж, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

7.1.2 Энэхүү гэрээнд үндэслэн хийгдсэн аливаа нэмэлт өөрчлөлт, хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

7.1.3 Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа ажлын 2 хоногийн өмнө мэдэгдэнэ. Саналыг хүлээн авсан тал хариуг ажлын 2 хоногийн дотор өгөх бөгөөд хариу өгөөгүй бол саналыг хүлээн зөвшөөрөөгүйд тооцно.

7.2 Захиалагч нь дараах үндэслэлээр гэрээг нэг талын санаачилгаар хугацаанаас нь өмнө цуцалж болно. Гэрээний аль нэг тал гэрээ цуцлах мэдэгдлийг нөгөө талдаа доорх зөрчлийг мэдсэнээс хойш ажлын 3 хоногийн дотор гаргана.

7.2.1 Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгээгүй, гэрээнд заасан шаардлагын дагуу биелүүлээгүй ба нэмэлт хугацаа тогтоож өгсөн боловч гүйцэтгэгч ажлыг гүйцэтгэхгүй нь тодорхой болсон бол захиалагчийн санаачилгаар.

7.2.2 Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний дагуух ажлыг гүйцэтгэх явцад захиалагч болон гуравдагч этгээдийн эрхийг зөрчсөн, мөн захиалагчид хохирол учруулсан, захиалагчийн талаар сөрөг мэдээлэл тараасан бол захиалагчийн санаачилгаар.

7.2.3 Захиалагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй, зохих ёсоор биелүүлээгүй, энэ тухай гүйцэтгэгч сануулсан боловч тодорхой үр дүнд хүрч чадаагүй бол гүйцэтгэгч тал гэрээг дангаар цуцлах эрхтэй.

7.3 Талууд энэхүү гэрээний 7.2-т зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлах тохиолдолд нөгөө талдаа энэ тухайгаа ажлын 3 хоногийн өмнө мэдэгдэх үүрэгтэй.

Найм. Бусад зүйл

8.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба Талууд гэрээний үүргээ зохих ёсоор гүйцэтгэснээр гэрээний үйлчлэл

Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас: 3/8

- дуусгавар болно. Энэхүү гэрээ нь энд дурдсан асуудалтай холбоотой бүхий л харилцан ойлголтыг бүрэн илэрхийлж байгаа бөгөөд гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхэлмэгц энэ гэрээнд хамаарах урьд өмнө яригдаж байсан талуудын хоорондын аман хэлэлцээр, протокол, захидал харилцаа нь хүчингүйд тооцогдоно.
- 8.2 Энэхүү гэрээний Талуудын эрх, үүрэг нь түүний эрх залгамжлагчид бүрэн хэмжээгээр нэгэн адил хамаарна. Талуудын удирдлага, бүтэц өөрчлөгдөж солигдсон явдал нь энэхүү гэрээг хүчингүй болгох, Талууд гэрээний үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 8.3 Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулах бол Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Гэрээний явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж Талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 8.4 Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн өвчтөний мэдээлэл, байгууллагын нууцад хамааралтай (техник, санхүү, бизнесийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад задруулахгүй байх үүргийг хүлээх ба зөрчсөн тохиолдолд хуульд заасан журмын дагуу хариуцлага хүлээнэ. Аль нэг талын гэрээний үүргээ зөрчсөн буруутай үйл ажиллагааны улмаас гэрээ цуцлагдсан бол үүргээ зөрчсөн тал гэрээ цуцлагдсаны улмаас нөгөө талд учирсан хохирлыг гэрээний нийт үнийн дүнд багтах хэмжээгээр хариуцан арилгана.
- 8.5 Талууд гэрээтэй холбогдон гарсан асуудлыг харилцан ярилцлага, зөвшилцлийн зарчмаар шийдвэрлэх ба шийдвэрлэж эс чадвал маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.6 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад талуудыг төлөөлөн харилцах эрх бүхий албан тушаалтан нь доор дурдсан хүмүүс байх ба гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. Үүнд:

Захиалагчийн төлөөлж:	Гүйцэтгэгчийг төлөөлж:
Нэр: Ц.Дулмаа	Нэр: О. Хулан
Албан тушаал: Хүний нөөцийн менежер	Албан тушаал: ОН Админ
Утас : 90790980	Утас: 89934400
Цахим хаяг: hrd@rcinspection.mn	Цахим хаяг: OHAdmin@buyant-clinic.com

- 8.7 Хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 8.8 Энэхүү гэрээг эх хувиар хоёр хувь үйлдэх ба хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

<p>Захиалагчийг төлөөлж :</p> <p>“Ар Си Инспекшн Азиа Ассайрс” ХХК-ийн Хүний нөөцийн менежер</p> <p> Ц.Дулмаа Хаяг: УБ хот, ХУД, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж 100/1 тоот Утас: 76108008, 90790980, 99110734</p>	<p>Гүйцэтгэгчийг төлөөлж :</p> <p>“Буянт-Оношлогоо” ХХК-ийн Нягтлан бодогч:</p> <p> Д.Баянзул Хаяг: УБ хот, СБД, 1-р хороо, УВН центрийн 5 давхарт Утас: 70104646, 70106767, 99035045</p>
---	--

Хяналтын гарын үсэг

“Буянт-Оношлогоо” ХХК-ийн хуулийн мэргэжилтэн Б.Төрбат

Гарын үсэг 

Утас: 99791211

Хуудсыг баталгаажуулсан:

 Хуудас: 4/8

Мэргэжлээс шалтгаалах өвчний илрүүлэгийн багц	
1. Биеийн ерөнхий үзүүлэлтүүд	1. Артерийн даралт 2. Зүрхний цохилтын тоо 3. Амьсгалын тоо 4. Захын цусан дахь хүчилтөрөгчийн хэмжээ 5. Биеийн жингийн индекс 6. Бүсэлхий ташааны харьцаа
2. Лабораторийн Шинжилгээнүүд	1. Цусны ерөнхий шинжилгээ 2. Шээсний ерөнхий шинжилгээ 3. Элэгний үйл ажиллагаа (АЛТ, АСТ, ГГТ, АЛФ) 4. Өлөн үеийн сахар 5. Бөөрний үйл ажиллагаа (Креатинин, Уреа, Шээсний хүчил) 6. Өөх тосны солилцоо (Нийт холестерин, триглицерид) Өндөр нягтралт липопротеинийг (50-аас дээш насанд)
3. Цээжний рентген зураг	1. Шинээр ажилд орж буй тохиолдолд хүн бүрт 2. Давтан үзлэгт орж буй тохиолдолд - Ижил өртөлтийн бүлгийн заалтын дагуу
4. Зүрхний Цахилгаан Бичлэг (40 наснаас дээш эсвэл эмчийн заалтаар)	1. Шинээр ажилд орж буй тохиолдолд хүн бүрт 2. Давтан үзлэгт орж буй тохиолдолд - Ижил өртөлтийн бүлгийн заалтын дагуу
5. Уушигны багтаамж/ Спирометри	1. Шинээр ажилд орж буй тохиолдолд хүн бүрт 2. Давтан үзлэгт орж буй тохиолдолд - Ижил өртөлтийн бүлгийн заалтын дагуу
6. Амьсгал хамгаалах хэрэгслийн тохироо үзэх /Quantifit2 аппаратаар/	Ижил өртөлтийн бүлгийн (ИӨБ) заалтаар хийгдэнэ.
7. Сонсголын бичлэг/ Аудиометри	1. Шинээр ажилд орох хүн бүрт эхний жилд 2 удаа хийнэ. 2. Давтан үзлэгт - Ижил өртөлтийн бүлгийн заалтын дагуу
8. Сонсгол хамгаалах хэрэгслийн тохироо үзэх / аппаратаар/	Ижил өртөлтийн бүлгийн заалтаар
9. Хараа шалгах	Титмус аппаратаар хараа шалгах (ажил мэргэжлээс нь хамаарч тохиргоогоо сонгоно)
10. Ишихара тест	Өнгө ялгах нь Титмус аппаратаар өөрчлөлттэй тохиолдолд Ишихара тест хийнэ
11. Үйл ажиллагааны чадавхийн үнэлгээ	1. Гарын атгах хүчийг динамометер аппаратаар шалгах 2. Үйл ажиллагааны чадавхийн дасгалууд



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас: 6/8

12. Зүрх, титэм судасны өвчний эрсдэлт хүчин зүйлийг урьдчилан таамаглах хүснэгт (50 наснаас дээш)	Зүрх, титэм судасны өвчний эрсдэлт хүчин зүйлийг урьдчилан таамаглах хүснэгтээр үнэлгээ хийж 50-с дээш насныханд өндөр нягтралт липопротеинийг нэмэлтээр үзэж үнэлгээ хийнэ.
13. Хөдөлмөрийн эрүүл мэндийн эмчийн үзлэг	Үзлэг, Зөвлөгөө, Дүгнэлт
Бүгд 235000 төг	

Нэмэлт тайлбар: Дээрхи үзлэг шинжилгээнд тодруулга хийх шаардлагатай бол нэмэлт шинжилгээ болон нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө санал болгох ба эдгээр нь нэмэлт төлбөртэй болно.

Clinically indicated medical assessments		
Онош тодруулах нэмэлт үзлэг		
Хэвлийн ЭХО	Abdominal Ultrasound	30.000₮
Сахарын гурван сарын дундаж	HbA1c	18.000₮
Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг	Additional assessment by specialized doctors such as cardiologist, psychiatrist, etc.	40.000₮
Честер степ тест (зөвхөн аврах багийг гишүүдэд хамааралтай)	Chester step test (to be performed only to emergency response staff)	20.000₮

Давуу тал

1. Буюнт-Оношлогоо эмнэлэг нь 2005 онд байгуулагдсан бөгөөд 16 жилийн хуагацаанд 4 удаа магадлан итгэмжлэгдсэн Монголын анхны хувийн эмнэлгүүдийн нэг юм.
2. “Бона Вита” Эмнэлзүйн нэгдсэн төв лаборатори нь олон улсын лавлагаа лабораторийн стандартын дагуу зохион байгуулагдсан бөгөөд MNS ISO 15189:2015 стандартын шалгуураар итгэмжлэгдсэн ба өдөр бүр 7 хоногийн 24 цагийн турш үйл ажиллагаа явуулан, түргэн шуурхай, найдвартай үйлчилгээг үзүүлдэг.
3. Мэргэжлээс шалтгаах өвчин судлалаар мэргэшсэн эмч бүрэн үзлэг, дүгнэлт хийж, мэргэжлийн тохироо гаргадаг
4. Оношлогооны хамгийн сүүлийн үеийн дүрс оношлогооны аппарат, техникээр тоноглогдсон.
5. Харааны талбайг зориулалтын тусгай багажаар хэмжинэ
6. Нэмэлт шинжилгээ шаардлагагүй тохиолдолд үзлэгийн дүгнэлт хувь хүн болон байгууллагад өдөртөө хүргэгддэг.
7. Хотын төвд байрлалтай.



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас: 7/8

Why Buyant Diagnostic clinic?

1. Buyant-Diagnostic Hospital was established in 2005 and one of the first private hospitals in Mongolia which has been accredited four times over 16 years.
2. Bona Vita laboratory is organized as international standards and certified MNS ISO 15189:2015 and works 24/7 and to ensure accuracy of the results, clear and through pre-testing instructions are given to each customer prior to screening.
3. Experienced occupational medical doctor provides final medical conclusion.
4. Our clinic is equipped with the latest modern imaging techniques.
5. High quality, non-human error proof equipment is used for diagnostics, for example Visual Field Perimeter Testing Equipment is used for checking peripheral vision.
6. If no additional examinations are needed, the pre-employment or PME finding and conclusion report will be ready on the same day.
7. Located in center of Ulaanbaatar.

89934400
80837700

ClinicManagerUB@buyant-clinic.com
OHAdmin@buyant-clinic.com

СБД, 1Р ХОРОО, 13Р ХОРООЛОЛ, УВН CENTER, 5-Н ДАВХАР

ХАВСРАЛТЫГ БАТАЛСАН:

Захиалагчийг төлөөлж :

“Ар Си Инспекшн Азиа Ассайрс”
ХХК-ийн Хүний нөөцийн менежер

..... Ц.Дулмаа

Хаяг: УБ хот, ХУД, 3-р хороо, Үйлдвэрийн
гудамж 100/1 тоот
Утас: 76108008, 90790980, 99110734

Гүйцэтгэчийг төлөөлж :

“Буянт-Оношлогоо” ХХК-ийн
Нягтлан бодогч:

..... Д. Баянзул
Хаяг: УБ хот, СБД, 1-р хороо, УВН
центрийн 5 давхарт
Утас: 70104646, 70106767, 99033697

.....

Хуудсыг баталгаажуулсан:

.....
Хуудас: 8/8